

## **НИЙСЛЭЛИЙН ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ, МЭРГЭЖИЛТНИЙ АЖЛЫН АЧААЛАЛ**

**Г.АНХЗАЯА**

ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн  
8072 дугаар дамжааны суралцагч, цагдаагийн ахмад;

**А.Гантуул**

ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн  
Удирдахуйн ухааны профессорын багийн дэд профессор,  
цагдаагийн хошууч

**Хураангуй:** Байгууллага бүр тодорхой зорилго дэвшүүлж, зорилгодоо хүрэхийн тулд олон чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд тэдгээрийн дотроос нөөцүүдийг оновчтой хуваарилж, зохион байгуулах нь менежерүүдээс ихээхэн мэдрэмж, ур чадвар шаарддаг. Аливаа байгууллагын амжилттай оршин тогтнохын үндэс нь удирдлагын зөв менежемент байдаг хэдий ч хүний нөөцийн удирдлагыг ухаалгаар хэрэгжүүлж ажилтан, албан хаагчдын тогтвор суурьпилтай ажиллах, ажилдаа дур сонирхолтой, бүтээлч, мэргэшсэн байх явдлыг хангах нь туйлын чухал. Үүний тулд нэн тэргүүнд тэдний ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, мэдлэг, ур чадварыг нь тасралтгүй хөгжүүлж байх шаардлагатай юм.

**Түлхүүр үг:** Ажлын онцлог, ажлын байрны тодорхойлолт, ажлын ачаалал, бүтэц зохион байгуулалт, эрх зүйн орчин.

### **Оршил**

"Тэмт явдалтай тэмцэх үйл ажиллагаа нь үр дүнтэй байх үндсэн нөхцөл, хүчин зүйлийн нэг бол түүнийг шинжлэх ухааны үндэстэйгээр илрүүлэн нотлох үндэсний тогтолцоо жинхэнэ утгаараа бүрэлдэн бий болох. улмаар боловсронгуй болж төгөлдөржих явдал мөн"<sup>1</sup> гэж авч үзсэн бөгөөд энэхүү утгаараа гэмт хэрэгтэй тэмцэхэд хэрэгт ач холбогдолтой ул мөр. эд мөрийн баримтыг олж тогтоох, түүнийг тусгай мэдлэгийн хүрээнд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр гэмт хэрэгтнийг илрүүлэх ажиллагааг хэрэгжүүлэгч субъект нь *шинжээч, мэргэжилтэн* юм.

Өнөөдөр шинжээч, мэргэжилтний ажлын ачаалалтай уялдан ажлын байрны онцлог, ажлын байрны орчин нөхцөл, нийгмийн баталгааны зэрэг олон асуудлууд хөндөгдөн яригдах болсон. Байгууллагын өмнө тулгараад байгаа асуудлуудыг нэг мөр цэгцлэх, эмх журамд оруулах нь удирдлагын бодлого, чиглэлээс ихээхэн хамаарна. Байгууллагын үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй

<sup>1</sup> Б. Лагвасүрэн . Хүний эрхэд суурилсан шинжлэн магадлах үйл ажиллагаа: онол, арга зүйн асуудал. УБ.,2017.Т.24.

зохион байгуулах, алба хаагчдын үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, ажлын ачааллыг зөв тодорхойлох арга замыг олж зохион байгуулах явдал юм.

Менежментийн шинжлэх ухааны агуулгаар үзвэл шинжээч. мэргэжилтний ажлын онцлог, ажлын байрнаас шалтгаалсан учирч болох хор хохирлоос хувь хүнийг хамгаалах нь хөдөлмөрийн оновчтой зохион байгуулалтыг илтгэх суурь үзүүлэлт төдийгүй, ажил олгогч байгууллагын үндсэн зорилго байх учиртай.

Аливаа сайн бүхэн уламжлагдаж байх учиртай, харин ажлын арга барил байнга өөрчлөгдөж шинэчлэгдэх ёстой.<sup>1</sup>

**Нэг. Ажлын ачаалал, түүнд нвлөөлөх хүчин зүйлсийг илтгэдэг нэр томъёог дараах утгаар ойлгож байна.**

Ажлын ачаалал, ажил хөдөлмөрийн зохион байгуулалтын талаар ХБНГУ-ын эрдэмтэн судлаачид бусад улс орнуудтай судлаач нартай харьцуулахад олон талаас нь судалсан байх тул ажил хөдөлмөр, хөдөлмөр зохион байгуулалтын тухай онолын ойлголтыг ХБНГУ-ын судлаачдын бүтээлүүд дээр тулгуурлан бичлээ.

ХБНГУ-ын философич Бертрант Рассэлл /Bertrand Russell/ хоёр төрлийн ажил байдаг гэж үзжээ. Үүнд:

Нэгдүгээрт: Газрын хөрсөн дээр юм уу, түүнтэй ойрхон оршиж, бусад материалтай холбоотой ямар нэг материйн байр байдлыг хувирган өөрчлөхөд чиглэсэн ажил, Энэ бол ажил, хөдөлмөрийн үндсэн утга буюу **“Бие хүчний”** ажил юм.

Хоёрдугаарт: Хүмүүс бусад матертай холбоотой ямар нэг материйн байр байдлыг хэрхэн хувирган өөрчлөхийг хэлж зааварлах ажил. Энэ бол ажил, хөдөлмөрийн бас нэг утга болох **“Оюуны ажил”** юм\*<sup>2</sup> гэжээ. Түүнчлэн судлаач Н.Содномдорж “Үйлдвэрлэл үйлчилгээний зорилгыг биелүүлэхэд чиглүүлэн зарцуулж байгаа” хүний биеийн болон оюуны үйл ажиллагааг **“хөдөлмөр”** гэнэ.<sup>3</sup> гэж тодорхойлсон байна.

Судлаачдын байр суурийг нэгтгэн үзэхэд “ажил”, “ажил хөдөлмөр” гэх ойлголт нь ижил утгатай бөгөөд **биений хүчний** болон **оюуны** гэсэн хоёр төрлийн ажил хөдөлмөр байна.

Эдгээр тодорхойлолтуудаас дүгнэж үзэхэд **“Ажил”** гэдэг нь хүн өөрийн хэрэглээндээ зориулан цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэг зүйлийг бүтээн бий болгох, бэлтгэх, боловсруулах үйл ажиллагаа, хийж гүйцэтгэх зорилт, даалгавар, үүрэг хариуцлагын нэгдэл гэж ойлгож болохоор байна.

Ц.Цэрэндорж. Бидний менежмент. УБ., 2010.Т. 23.

<sup>2</sup> Russell B6Lob Des Mubiggans.London.1935.

<sup>3</sup> Содномдорж Н. *Орчин үеийн хөдөлмөрийн эдийн засаг* . УБ., 2000.т.5

Биеийн хүчний болон оюуны ажил хөдөлмөр эрхлэх үйл явц нь хүний бие организмд ямар нэгэн үр нөлөө үзүүлж байдаг бөгөөд энэхүү үр нөлөө үзүүлж байгаа хүчин зүйлийн хэмжээг **“ачаалал”** гэнэ хэмээн судлаач В.Лаурих үзжээ.

ХБНГУ-ын Стандартчлал, хэмжил зүйн хүрээлэнгээс гаргасан ажлын зохион байгуулалтыг сайжруулахад тавих нийтлэг шаардлагад **“Ажлын ачаалал”** гэж хүний биеийн ба сэтгэл зүйн байдалд ажлын байранд тавигдах шаардлагууд болон ажиллах орчин нөхцлийн үзүүлж байгаа нөлөөллийн цогцыг хэлнэ” гэж тодорхойлжээ. Энэ тодорхойлолтод дурьдсан "ажлын систем" гэдэгт ойлголт бий бөгөөд үүнд ажилтан ажлын хэрэгсэл зэргийг ойлгодог.<sup>1</sup>

Түүнчлэн судлаач Р.Бюдинг, Л.Дюринг нар **“Ажлын ачаалал”** гэдэг нь ажлыг гүйцэтгэхэд бие организм, мэдрэл, оюун санаанд тусдаг нөлөө бөгөөд ажилтан ажлыг ажил хэрэгчээр, зорилго чиглэлтэй гүйцэтгэхийн тулд энэхүү нөлөөг тэсвэрлэх хэрэгтэй болно гэж үзсэн.<sup>1 2</sup> Ачаалалд хүмүүс харилцан адилгүй хариу үйлдэл үзүүлж, түүний дарамтыг янз бүрээр мэдэрч байдаг учраас хувь хүмүүст ачааллын үзүүлэх нөлөөг баттай тогтоох боломжгүй юм.

Харин ажлын байран дахь "ачаалал" нь ажлын байрны зохион байгуулалт, ажлын орчин нөхцөл эсвэл ажилтай холбоотой нийгмийн харилцаа холбоотойгоор ажлын байр болгонд харилцан адилгүй хэмжээтэй бий болдог ажээ.

Монгол хэлний тайлбар тольд **“Ачаалал”** гэдэг нь зохих хүч чадлын хэм хэмжээнд тохирох ажил үүрэг, хувь, **“Ажлын ачаалал”** гэдэг нь хийх ажлын хэмжээ, **“Ажил ихдэх”** гэдэг нь хийвэл зохих ажил оногдсон хэм хэмжээнээсээ хэтрэх<sup>3</sup> гэж тайлбарласан байна.


Дээрхээс дүгнэж үзвэл ажлын ачаалал нь байгууллагын хувьд үйл ажиллагааны болон нийгмийн зардал ихтэй байдаг бөгөөд байгууллагын үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах асуудал чухал юм. Үүнтэй уялдуулан онолын дээрх ойлголт дээр тулгуурлан дараах байдлаар ажлын ачааллыг авч үзэхийг зорилоо.

Нийслэлийн шүүхийн шинжилгээний албаны шинжээч, мэргэжилтэн нь дүүргийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн дуудлаганд бүрэлдэхүүний хамт үзлэг хийж ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлж бэхжүүлэн, хураан авч. тогтоол захирамжийг үндэслэн шинжилгээ хийж дүгнэлт гаргадаг.

<sup>1</sup> REFA Verband für Arbeitsstudien und Betriebsorganisation e. V.2002.

<sup>2</sup> Oesterreich.R Das belastung Beanspruchungskonzeptim vergleich mit arbeitspsychologischen konzepten, institut für angewandte informatik techinsche universitat.Berlin.

<sup>3</sup> Я.Цэвэл. Монгол хэлний тайлбар толь. УБ.,1966. т.27



Шинжээч, мэргэжилтэн нь өдөр, шөнө, халуун хүйтэн аль ч нөхцөлд хүний амь нас хохирсон, хулгай, дээрэм, хүчин. галт түймрийн зэрэг тухайн хоногийн хугацаанд гарсан бүхий л гэмт хэргийн дуудлаганд ажиллаж, ул мөр илрүүлж бэхжүүлэх, нотлох баримт цуглуулах үүрэг хүлээдэг.


Иймд шинжээч, мэргэжилтний ажлын онцлогийг тодорхойлон дараах үе шаттайгаар тодорхойлсон болно. Үүнд:

Хүснэгт I

| Д/д     |                                                                                                                                                                                                        | АЖЛЫН ОНЦЛОГ                                                   |
|---------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------|
| Шинжээч |                                                                                                                                                                                                        | Мэргэжилтэн                                                    |
| 1.      | Тогтоолтой танилцах “Шинжээчид тавьсан асуулг                                                                                                                                                          | Хэргийн газрын үзлэгийг гэрэл зургаар бэхжүүлэх                |
| 2.      | Шинжилгээний бүртгэлийн дэвтэрт хөтлөх “шинжилгээнд ирүүлсэн объектын тоо, томилсон албан тугаалтан, шинжилгээ хийж байгаа шинжээчийн нэр, үгүйсгэсэн, татгалзсан, тохирсон, харьцуулах загварын тоо”” | Гутлын мөр, тээврийн хэрэгслийн мөр илрүүлж, бэхжүүлэх         |
| 3.      | Үзлэг ба шинжилгээ “Шинжилгээний үе шат ”                                                                                                                                                              | Эвдлэгч багаж, хэрэгслийн мөр илрүүлж, бэхжүүлэх               |
| 4.      | Дүгнэлт бичих                                                                                                                                                                                          | Гарын мөр илрүүлж, бэхжүүлэх                                   |
| 5.      | Гэрэл зургийн үзүүлэлт хийх “Шинжилгээний төрөл”                                                                                                                                                       | Биологийн гаралтай ул мөр, эд мөрийн баримт илрүүлж, бэхжүүлэх |
| 6.      | Дүгнэлтийг хаалгаж үлдэх хувийг архивт хадгалах. шинжилгээ томилсон албан тушаалтанд хүлээлгэн өгөх                                                                                                    | Бусад ул мөр, эд мөрийн баримт илрүүлж, бэхжүүлэх              |
| 7.      | -                                                                                                                                                                                                      | Илрүүлж, бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримтаа хаяглан         |

|    |  |                                    |
|----|--|------------------------------------|
|    |  | бигтүүмжилж хүлээлгэн өгөх         |
| 8. |  | Цогцосны гадна үзлэг               |
| 9. |  | Цогцосны задлан шинжилгээний үзлэг |

Хүснэгт 2



Дээрх тоон үзүүлэлтээс үзэхэд Нийслэлийн шүүхийн шинжилгээний газрын Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул, Баянгол, Багануур, Баганхангай дүүргийн шинжээч, мэргэжилтэн хоногт дундажаар 5-9 гэмт хэргийн газарт ажиллаж ул мөр илрүүлж, бэхжүүлэх ажиллагаа, мөн тухайн гарсан өдрийн гэмт хэргийн газраас бэхжүүлэн авсан ул мөр, эд мөрийн баримтандаа үзлэг шинжилгээ хийдэг байна. Шинжээч, мэргэжилтэн 24/72 цагийн жижүүрийн үүрэг гүйцэтгэдэг боловч ээлжийн амралт эдлэх, сургалтын чөлөө авах, өвчний чөлөө авах, ар гэрт гачигдал тохиолдох зэрэгт жилийн ихэнхи үед 24/48 цагаар, зарим тохиолдолд 24/24 цагийн хүртэл үүрэг гүйцэтгэх явдал цөөнгүй байна.

Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн 70 дугаар зүйлд 70.1-д “Долоо хоногийн ажлын цаг 40 цаг хүртэл байна”<sup>1</sup> гэж заасан нь дүүргийн шинжээч, мэргэжилтэн долоо хоногт дунджаар 72 цаг, шинжилгээ хийх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлж байгаагаас хамаарч дунджаар 15 цаг хүртэл ажиллаж, долоо хоногт дунджаар шинжээч 80 гаруй цаг, тогтмол илүү цагийн ачаалалтай ажиллаж байгаа юм.

<sup>1</sup> Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль. 1993.

## Хэргийн газарт болон шинжилгээ хийх үе шатуудын хугацаа зарцуулалт

| Д/Д                                 | Үзлэгийн үе шатууд                                                                                                                                                                                            | Хэргийн өнгө  |               |
|-------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------|---------------|
|                                     |                                                                                                                                                                                                               | Учрал         | Бусад         |
| Мэргэжилтэн                         |                                                                                                                                                                                                               |               |               |
| 1                                   | Гэрэл зураг бэхжүүлэх хугацаа                                                                                                                                                                                 | 30 минут      | 30 минут      |
| 2                                   | Гутлын мөр, тээврийн хэрэгслийн мөр илрүүлж, бэхжүүлэх хугацаа                                                                                                                                                | 15 минут      | 15 минут      |
| 3                                   | Эвдлэгч багаж, хэрэгслийн мөр илрүүлж, бэхжүүлэх хугацаа                                                                                                                                                      | 15 минут      | 15 минут      |
| 4                                   | Гарын мөр илрүүлж, бэхжүүлэх хугацаа                                                                                                                                                                          | 30 минут      | 30 минут      |
| 5                                   | Биологийн гаралтай ул мөр, эд мөрийн баримт илрүүлж. бэхжүүлэх хугацаа                                                                                                                                        | 30 минут      | 30 минут      |
| 6                                   | Бусад ул мөр, эд мөрийн баримт илрүүлж, бэхжүүлэх хугацаа                                                                                                                                                     | 15 минут      | 15 минут      |
| 7                                   | Илрүүлж, бэхжүүлсэн ул мөр, эд мөрийн баримтаа хаяглан битүүмжилж хүлээлгэн өгөх хугацаа                                                                                                                      | 30 минут      | 30 минут      |
| 8                                   | Цогцосны үзлэг хийх хугацаа                                                                                                                                                                                   | 30 минут      |               |
| Мэргэжилтний зарцуулах нийт хугацаа |                                                                                                                                                                                                               | 195 минут     | 165 минут     |
| Шинжээч                             |                                                                                                                                                                                                               |               |               |
| Д/Д                                 | Үе шат                                                                                                                                                                                                        | Шинжилгээ     |               |
|                                     |                                                                                                                                                                                                               | Гарын мөр     | Мөр судлал    |
| 1.                                  | Тогтоолтой танилцах <i>"Шинжээчид тавьсан асуулт"</i>                                                                                                                                                         | 5 минут       | 5 минут       |
| 2.                                  | Шинжилгээний бүртгэлийн дэвтэрт хөтлөх <i>"шинжилгээнд ирүүлсэн объектын нүо, томилсон албан тушаалтан, шинжилгээ хийж байгаа шинжээчийн нэр, үгүйсгэсэн, татгалзсан, няхирсон, харьцуулах загварын тоо "</i> | 10 минут      | Юминут        |
| 3.                                  | Үзлэг ба шинжилгээ <i>"Шинжилгээний үе шат "</i>                                                                                                                                                              | 250-350 минут | 250-380 минут |
| 4.                                  | Дүгнэлт бичих                                                                                                                                                                                                 | 20-30 минут   | 20-30 минут   |
| 5.                                  | Гэрэл зургийн үзүүлэлт хийх <i>"Шинжилгээний төрөл"</i>                                                                                                                                                       | 30-60 минут   | 30-60 минут   |
| 6.                                  | Дүгнэлтийг хаалгаж үлдэх хувийг архивт хадгалах, шинжилгээ томилсон албан тушаалтанд хүлээлгэн өгөх                                                                                                           | 20 минут      | 20 минут      |
| Шинжээчийн зарцуулах нийт хугацаа   |                                                                                                                                                                                                               | 425 минут     | 435 минут     |

Шинжээч, мэргэжилтэн 24 цагийн жижүүрийн үүрэг гүйцэтгэх хугацаанд гарсан гэмт хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцохоос гадна хэргийн газраас ирүүлсэн ул мөр, эд мөрийн баримтанд үзлэг шинжилгээ хийж дүгнэлт

гаргадаг. Энэ нь 24 цагийн жижүүрийн үүрэг гүйцэтгэх хугацаанд ажлын цагт багтдаггүй бөгөөд үүнээс болж шинжээч ээлжээс буусны дараа шинжилгээ хийхдээ амрахгүй ажиллаж байна. Үүнээс үүдэн шинжээчийн ажлын чанар, үр дүнд сөргөөр нөлөөлж байна. Шинжилгээг тодорхой үе шат дарааллаар заавал хийж гүйцэтгэдэг бөгөөд нэг үе шат алгасаад хийгдэхэд дүгнэлт бодит үнэн чанараа алдаж, үгүйсгэгдэх сөрөг талтай байдаг.

Шинжээч, мэргэжилтний ажил үүргийн зорилго нь гэмт хэрэг илрүүлэх, нотлоход хэргийн газраас гэмт этгээдийн үлдээсэн ул мөрийг ирүүлэх, шинжилгээ хийж дүгнэлт гаргах явдал тул ажлын хэт их ачааллын улмаас хэргийн газрын үзлэг чанаргүй хийгдэж, гэмт этгээдийг шинжлэх ухааны үндэстэй нотлон тогтоох боломжийг алдах эрсдэл үүсгэж байна. Иймээс энэ асуудлыг удирдлага, зохион байгуулалтын түвшинд шийдвэрлэх зорилгоор шинжээч, мэргэжилтнээс ажлын ачааллын бодит үнэнийг тодорхойлж, алба хаагчийн эрх зүйн баталгаа, ажиллах орчин нөхцлийг сайжруулж, цаашлаад учирч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх шаардлагатай. Үүний хүрээнд ажлын ачаалал үүсгэж байгаа хүчин зүйлийг тодорхойлох, алба хаагчдын ажлын байрны тодорхойлолт өнөөдрийн байдлаар бодит шаардлагад нийцсэн байх, мэргэжилтний эрх, үүрэг, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хүний нөөцийн бодлогыг дахин шинэчлэх шаардлагатай гэж үзэж байна.

**ДҮГНЭЛТ:** Нийгмийн нөхцөл байдлаас шалтгаалан жилээс жилд гэмт хэргийн гаралт өсч, гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн байгууллагуудын алба хаагчдын ажлын ачаалал нэмэгдсээр байна. Тэр дундаа шинэ төрлийн гэмт хэргийн гаралт ихсэх болсон нь шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтний ажлын ачааллыг эрс нэмэгдүүлэх болсон юм.

Өнөөдөр шинжээч, мэргэжилтний хоногт хийж гүйцэтгэх ажил үйлчилгээг шинжлэх ухааны үндэслэлтэй тооцож, тэдний ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, чанартай ажил үйлчилгээг иргэдэд үзүүлэхэд чиглэсэн менежементийн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна гэж дүгнэлээ.

**САНАЛ:** Нийслэлийн шүүхийн шинжилгээний албаны шинжээч, мэргэжилтний ажлын ачааллыг тэнцвэржүүлэхэд удирдлага зохион байгуулалтын дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай гэсэн дүгнэлтийг судлаачийн зүгээс дэвшүүлж байна. Үүнд:

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгад мэргэжилтний эрх, үүрэг, үйл ажиллагааны чиглэлийг зохицуулсан хэсгийг нэмж оруулах;

Шинжээч, мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтыг ажлын байрны шинжилгээ, чиг үүрэгтэй нь нийцүүлэн шинэчлэх, зарим давхардал хийдлийг арилгах;